



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/28

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 50,000,000 (тавин сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх аймгийн "Жангар" музейн үзүүлэг дэглэлтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлэх эрхийг аймгийн "Жангар" музейн захирал (Ш.Насан)-д шилжүүлсүгэй.

2. Ажил гүйцэтгэх хугацаа, ажлын төлөвлөгөөг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүргийг хэрэгжүүлж, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн "Жангар" музейн захирал (Ш.Насан)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramj Zax ZD 2025

8200010003

